



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 28 31 79, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrt.gov.mn,
Цахим хуудас: www.mrt.gov.mn

2026.02.13 № 01/744
танай 2026.01.22 -ны № 04 -т

Асуулгын хариу

Эрхэм гишүүн таны асуулгын дагуу Завхан аймгийн Сонгино сумаас Увс аймгийн Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто замын ПК553–573 хоорондын 20 км авто замын зорчих хэсгийн асфальтобетон хучилтад үүссэн эвдрэлийн нөхцөл байдал, шалтгаан, тулгараад буй асуудал, эвдрэлийг засварлуулах талаар тус яамнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл, холбогдох баримт материалыг хүргүүлж байна.

Дээрх чиглэлийн авто замыг "Хос мөнгөн зам" ХХК концессын "Барих-шилжүүлэх" гэрээгээр хэрэгжүүлж, 2019 оны 12 сард ашиглалтад оруулсан бөгөөд концессын гэрээний тал бөгөөд эрх бүхий этгээд нь Эдийн засаг, хөгжлийн яам болно.

Ашиглалтад ороод жил 4 хүрээгүй хугацаанд авто замын хучилтад технологийн алдаанаас шалтгаалсан хагарал, эвдрэл гарч эхэлсэн бөгөөд Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын /хуучнаар/ 2021 оны төлөвлөгөөт хяналт, шалгалтаар эвдрэл гарсаныг тогтоон, илэрсэн дутагдлыг арилгуулах талаар Авто замын Улсын Ахлах байцаагчийн 01-07-035/275, 2023 онд Зам, тээврийн хөгжлийн яамны Улсын ахлах байцаагчийн 04-00-02/007/184 дүгээр албан шаардлагуудыг концесс эзэмшигчид тус тус хүргүүлж, мөн шалгалтаар илэрсэн дутагдлууд, үүсээд буй нөхцөл байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээний Авто замын Улсын байцаагчийн дүгнэлт гарган, Эдийн засаг, хөгжлийн яаманд албан бичгээр хүргүүлж байсан. /Дүгнэлт, шаардлагуудыг хавсаргав/

Авто замын тухай хууль болон концессын гэрээний дагуу авто замын чанарын баталгаат хугацаа 3 жил ба баталгаат хугацаанд авто замд технологийн эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд концесс эзэмшигч өөрийн хөрөнгөөр засварлах үүрэгтэй.

Төслийн чанарын баталгаат хугацаанд гарсан технологийн эвдрэлүүдийг цаг тухай бүр норм, дүрэм, техникийн шаардлагын дагуу засварлаагүйн улмаас авто замын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдал алдагдаж, тухайн чиглэлийн авто замаар зорчиж буй жолооч тээвэрчид, аялагч жуулчид, ард иргэд эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирч байгаа тул замын эвдрэлийг засварлуулах, концессын гэрээний хэрэгжилтийг хангуулах, хууль хяналтын байгууллагад хандаж хохирлыг барагдуулах, хариуцлага тооцуулах, концессын гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй ажлын зардлыг концесс эзэмшигчээс гаргуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар Эдийн засаг, хөгжлийн яаманд удаа дараа албан бичгээр хүргүүлсэн боловч концесс эзэмшигч засварын ажлыг шаардлагын хэмжээнд хийж, хүлээлгэн

өгөөгүй байна. /Хүргүүлсэн албан бичгүүдийг хавсаргав/

Концессын гэрээний үүргийг хангуулах хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамнаас "Хос мөнгөн зам" ХХК-тай холбогдуулан Монголын Үндэсний худалдаа, Аж үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт нэхэмжлэл гаргасан бөгөөд уг нэхэмжлэлийг 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр арбитр хүлээн авч, 114/25 дугаартай хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлээд байгаа тухай мэдээллийг 2025 оны 01/2163 тоот албан бичгээр тус яаманд ирүүлээд байна. /Нэхэмжлэлтэй холбоотой баримт бичгүүдийг хавсаргав/

Баталгаат хугацаанд технологийн алдаанаас үүдэн гарсан эвдрэлийг концесс эзэмшигч засварлаагүйгээс шалтгаалан уг авто замаар зорчиж буй иргэд байнгын ноцтой эрсдэлд өртөх нөхцөл байдал үүссэн тул улсын чанартай авто замын сүлжээний бэлэн байдал, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүргийн хүрээнд тус яамнаас уг чиглэлийн авто замыг "АЗЗА Нэгтгэл" ТӨХК-д хариуцуулан, өвлийн улиралд Сонгино суманд шуурхай ажлын хэсгийг байршуулж, цас цэвэрлэх, халтиргаа гулгааг арилгах арга хэмжээг авч, зуны улиралд чанарын баталгаат хугацааны засварын ажлыг хийж гүйцэтгэх хүртэл хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор 2024 онд 180.14 сая төгрөгийн санхүүжилтээр нүхэн эвдрэлийг цементээр бэхжүүлсэн шороон материалаар дүүргэх, 2025 онд дахин 299.86 сая төгрөгийн санхүүжилтээр дээрхтэй адил засварын ажлыг гүйцэтгэсэн болно.

Чанарын баталгаат хугацаанд гарсан эвдрэлийг "Хос мөнгөн зам" ХХК-аар засварлуулах, учирсан хохирлыг тус компаниар гаргуулах асуудлыг түргэвчлүүлэх талаар хуулийн хүрээнд дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллахыг Танаас хүсье.

Хавсралт 40 хуудастай.



Зам, тээврийн яам
Сайд
Б.Дэлгэрсайхан
2026.02.15 18:48



Г ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД
Б.ДЭЛГЭРСАЙХАН ТАНАА 7

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД**

Улаанбаатар, Чингэлтэй, 4-р хороо, Самбуугийн гудамж,
Засгийн газрын 11-р байр
Утас: 51263333, Факс: 51263333
Цахим шуудан: info@med.gov.mn
Цахим хуудас: www.med.gov.mn

2025.08.14 № 01/2163

танай _____-ны № _____-т

Г Хариу хүргүүлэх тухай 7

Концессын “барих-шилжүүлэх” нөхцөлтэй гэрээгээр хэрэгжиж 2019 онд ашиглалтад орсон “Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам”-ын чанарын баталгаат хугацаанд гарсан технологийн эвдрэлийн асуудлаар танаас 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдөр ирүүлсэн албан бичигтэй танилцлаа.

Уг асуудлаар Эдийн засаг хөгжлийн яамнаас концессын гэрээний хүрээнд Монгол Үндэсний Худалдаа Аж үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт нэхэмжлэл гаргасныг 2025 оны 05 дугаар сарын 29-ний хүлээн авч 114/25 дугаартай Эдийн засаг, хөгжлийн яамны нэхэмжлэлтэй “Хос мөнгөн зам” ХХК-д холбогдох хэрэг үүсгэж, хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлээд байна.

Нэхэмжлэлийн шаардлагад авто замын баталгаат хугацаанд үүссэн эвдрэлийн улмаас хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах түр арга хэмжээнд зарцуулагдсан зардал болон авто замын баталгаат хугацаанд гарсан эвдрэлийг засварлах ажлын зардлыг гаргуулах асуудал тусгагдсан.

Монголын Олон Улсын арбитрт Эдийн засаг, хөгжлийн яамнаас гаргасан нэхэмжлэл болон арбитрын хэрэг үүсгэсэн талаарх баримт, материалыг хавсаргав.

Хавсралт: 12 хуудастай.



Эдийн засаг, хөгжлийн яам
Удирдлага
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг,
хөгжлийн сайд
Ням-осор Учрал
2025-08-14 12:11:31



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
ЯАМ-Д

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ДЭРГЭДЭХ
МОНГОЛЫН
ОЛОН УЛСЫН АРБИТР

17011, УБ шуудан 101011001, Улаанбаатар хот,
Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, М.Гандигийн гудамж,
МҮХАҮТ-ын байр, Утас: 7011 1545, Факс: (976-11) 32 46 20,
Цахим шуудан: info@arbitr.mn, Вэбсайт: www.arbitr.mn

2025.05.29 № 4/1028
танай _____ -ны № _____ -г

Нэхэмжлэл хүлээн авсан тухай

Хэргийн дугаар 114/25
Эдийн засаг хөгжлийн яамны нэхэмжлэлтэй
“Хос мөнгөн зам” ХХК-д холбогдох хэрэг

Нэхэмжлэгч: Эдийн засаг, хөгжлийн яам /РД:2613409/

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж Засгийн газрын XI байр

Утас: 51263333

Итгэмжлэгдсэн төлөөлөгч: Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн П.Түвшин, Б.Билгүүннاران, төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Б.Баасансүрэн

Хариуцагч: “Хос мөнгөн зам” ХХК /РД:5926955/

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, бага тойруу, Монжинбар ХК-ийн байр

Утас: 99111543

Тус арбитра нэхэмжлэгч талаас доорх нэхэмжлэлийн шаардлага ирүүлжээ. Үүнд:

Нэхэмжлэлийн шаардлага: Монгол Улсын Засгийн газар нь “Хос мөнгөн зам” ХХК-тай 2017 оны 2 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан “Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5-км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн барих-шилжүүлэх (ВТ) концессын гэрээтэй тус гэрээний дагуу концесс эзэмшигч “Хос мөнгөн зам” ХХК нь концессын зүйлийн буюу авто замын баталгаат хугацаанд хэвийн ашиглалтыг хангаагүй, авто замд гарсан эвдрэл гэмтлийг засварлаагүйтэй холбогдуулан дараах дараах нэхэмжлэлийн шаардлагыг гаргаж байна. Үүнд:

1. Авто замын баталгаат хугацаанд үүссэн эвдрэлийн улмаас хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах түр арга хэмжээнд зарцуулагдсан 180,139,486 (нэг зуун наян сая нэг зуун гучин есөн мянга дөрвөн зуун наян зургаа) төгрөг

2. Авто замын баталгаат хугацаанд гарсан эвдрэлийг засварлах ажлын зардлыг гаргуулах тухай.

Монгол Улсын Арбитрын тухай хуулийн дагуу та энэ захидлыг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор арбитрчаа томилно уу. Та арбитрт ирүүлэх баримтаа 5 хувь илгээх ёстой.


Хэрэв энэ бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор арбитрчийг томилоогүй бол Арбитрын дарга томилно.

Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн 9.1 дүгээр зүйлийн дагуу арбитрч бүр талуудаас хараат бус байх бөгөөд хараат бус хэвээр үлдэх ёстойг анхаарна уу. Иймээс танай сонгосон арбитрч хараат бус, бие даасан гэдгийг бидэнд батална уу.

Дээрх зүйлтэй холбоотой аливаа асуудал байвал бидэнтэй доорх утсаар холбоо барина уу. Утас: 70111545

Хавсралт: Арбитрын тухай хууль болон Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийг доорх цахим хаягаар орж үзнэ үү. /www.arbitr.mn /

ЕРӨНХИЙ НАРИЙ
БИЧГИЙН ДАРГА



М.ШИНЭБАЯР



**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД**

Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2025. 05. 16 № 01/1371
танай _____-ныг № _____-т

Нэхэмжлэл гаргах тухай

Нэхэмжлэгч:

"Эдийн засаг, хөгжлийн яам" (РД: 2613409)

Хаяг/шуудангийн хаяг: Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж Засгийн газрын XI байр, Улаанбаатар хот 15141, Монгол Улс

Утас: +976-51263333

Цахим шуудан: info@med.gov.mn

Итгэмжлэгдсэн төлөөлөгчид:

Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн П.Түвшин, Б.Билгүүннэран

Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Б.Баасансүрэн

Хариуцагч:

"Хос мөнгөн зам" ХХК (РД:5926955)

Хаяг/шуудангийн Улаанбаатар, Чингэлтэй, 6-р хороо, бага тойруу, Монжинбар ХК-ийн байр

Утас: +976-99111543

Цахим шуудан: ; dualsilverroad@yahoo.com

Нэхэмжлэлийн шаардлага:

Монгол Улсын Засгийн газар¹ нь "Хос мөнгөн зам" ХХК-тай 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн барих-шилжүүлэх (ВТ) концессын гэрээтэй, тус гэрээний дагуу концесс эзэмшигч "Хос мөнгөн зам" ХХК нь концессын зүйлийн буюу авто замын баталгаат хугацаанд хэвийн ашиглалтыг хангаагүй, авто замд гарсан эвдрэл гэмтлийг засварлаагүйтэй холбогдуулан дараах нэхэмжлэлийн шаардлагыг гаргаж байна. Үүнд:

¹ Тус гэрээний нийтлэг үндэслэл хэсэгт заасанчлан "Монгол Улсын Засгийн газар"-ыг төлөөлж Засгийн газрын тохируулагч агентлаг "Үндэсний хөгжлийн газар" нь гэрээг байгуулсан. Үндэсний хөгжлийн газрын зохион байгуулалтын бүтцийг Засгийн газрын 2016 оны 38 дугаар тогтоолоор баталсан бөгөөд тус тогтоолын 1 дүгээр зүйлийн "в" дэх хэсэгт заасанчлан "Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын хэлтэс (концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн албатай)"-тай байхаар баталсан. Тус агентлагийн үйл ажиллагаа 2022 он хүртэл үргэлжилсэн бөгөөд Засгийн газрын 2022 оны 14 дүгээр тогтоолоор татан буулгаж, одоогийн Эдийн засаг, хөгжлийн яам нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр байгуулагдсан. Засгийн газрын 2022 оны 12 дугаар тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар"-ыг баталж, 2024.07.24-ны өдрийн 06 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан бөгөөд тухайн бүтцийн 5 дахь хэсэгт "Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газар (Төсөл хөгжүүлэлтийн хэлтэс, Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтэс, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтэстэй)" байхаар тогтоосон тул Эдийн засаг, хөгжлийн яам нь Засгийн газрыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байна.

250397

1. Авто замын баталгаат хугацаанд үүссэн эвдрэлийн улмаас хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах түр арга хэмжээнд зарцуулагдсан 180,139,486.00 (нэг зуун наян сая нэг зуун гучин есөн мянга дөрвөн зуун наян зургаа) төгрөг;
2. Авто замын баталгаат хугацаанд гарсан эвдрэлийг засварлах ажлын зардал.

Нэхэмжлэлийн үндэслэл:

Монгол Улсын Засгийн газар нь "Хос мөнгөн зам" ХХК-тай 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хурлын 2009 оны "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай" 64, Концессын тухай хууль, Засгийн газрын 2013 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай" 317, Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 213 дугаар тогтоол, Засгийн газрын хуралдааны 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 63 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн барих-шилжүүлэх (ВТ) концессын гэрээ байгуулсан, гэрээ хэвийн хэрэгжиж байтал концесс эзэмшигч "Хос мөнгөн зам" ХХК нь авто замын баталгаат хугацаанд эвдрэл гэмтэл үүсэхэд засварлахгүй саатуулж эхэлсэн. Үүнийг удаа дараа засварлахыг шаардсан боловч гэрээний үүргээ биелүүлээгүй учир тус арбитрад дараах хоёр үндэслэлээр нэхэмжлэл гаргаж байна.

Нэгдүгээрт, Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тухай

2017 оны 02 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн барих-шилжүүлэх (ВТ) концессын гэрээний 1.8, 1.10, 2.21 дэх хэсэгт концессын зүйлийг ашиглалтад хүлээлгэн өгсөн өдрөөс хойш түүний хэвийн ашиглалтын **баталгаат хугацаа 3 жил** байх бөгөөд тус хугацаанд авто замд технологийн эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд **концесс эзэмшигч нь өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцаж, урсгал засвар, арчлалтын ажлыг хийх үүрэг** хүлээхээр заасан.

Мөн тус концессын гэрээний 1.7 дахь хэсэгт авто замыг 2017 оны 07 дугаар сарын 30-ны өдөр ашиглалтад оруулахаар тохиролцсон ч 2017.05.02, 2018.08.29, 2019.03.19-ны өдрүүдийн гурван удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр авто замын ашиглалтад оруулах эцсийн хугацааг 2019 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр болгон хойшлуулсан.

Концессын гэрээгээр хэрэгжсэн 135.5 км хатуу хучилттай авто замын "83.3 км авто зам"-ыг 2019.01.30-ны өдрийн 07/15/18 дугаар "Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах ажлын хэсгийн дүгнэлт"-ээр байнгын ашиглалтад 2019.01.30-ны өдрөөс оруулахаар шийдвэрлэсэн. Мөн авто замын үлдсэн хэсэг болох 52.2 км авто замыг 2019.12.27-ны өдрийн 10/18/19 дугаар "Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах ажлын хэсгийн дүгнэлт"-ээр нийт 9 үүрэг даалгаврыг ажлыг хэсгээс өгсөн бөгөөд ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн гүйцэт зураг төсөл, техникийн шаардлагын дагуу биелүүлсний дараагаар 2020.06.01-ний өдрөөс эхлэн авто зам, замын байгууламжийн чанарын баталгаат хугацааг 3 жилээр тооцох, байнгын ашиглалтад оруулан үйлчилгээний зориулалтаар 2019.12.27-ны өдрөөс оруулахаар шийдвэрлэсэн.

Баталгаат хугацаанд илэрсэн эвдрэл гэмтэл, дутагдлыг арилгуулахаар хамгийн анх Монгол Улсын Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагч "Илэрсэн дутагдлыг арилгуулах тухай" 2022.07.20-ны өдрийн 01-07-035/143 дугаар албан шаардлагаар Хяргас нуур талаас 556км-ээс 573км-ийн хооронд авто замд гарсан эвдрэлийг холбогдох норм, аргачлалын дагуу засварын ажлыг хийж гүйцэтгэх, албан шаардлагын хэрэгжилтийг 2022.09.20-ны өдрийн дотор биелүүлэх арга хэмжээ авч, **зөвлөх байгууллагаар баталгаажуулж** ирүүлэхийг "Хос мөнгөн зам" ХХК-д даалгасан.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2022.09.13-ны өдрийн 03/4162 дугаар албан бичгээр "Концесс эзэмшигч нь концессын гэрээнд заасан баталгаат хугацааны засвар, арчлалтын ажлыг хугацаанд нь гүйцэтгэхгүй байгаагаас хөдөлгөөний аюулгүй байдал хангагдахгүйд хүрч, зам, тээврийн осол гарах нөхцөл бүрдсэн тухай" мэдээллийг ирүүлсэн тул нэхэмжлэгч Эдийн засаг, хөгжлийн яам нь 2022.09.27-ны өдрийн 03/1071 дугаар албан бичгээр "Хос мөнгөн зам" ХХК-д концессын гэрээний 2.21-т заасны дагуу баталгаат хугацааны засвар, арчлалтыг яаралтай хийж гүйцэтгэн, хэрэгжилтийг хяналтын **зөвлөх компаниар хянуулан ирүүлэхийг** мэдэгдсэн.

Хяналтын зөвлөх компани "Ар Си Эс Си" ХХК нь 2022.11.21-ны өдрийн 242/22 дугаар албан бичгээр нэхэмжлэгчид "Хос мөнгөн зам" ХХК нь 2019 оны 12 дугаар сард ашиглалтад хүлээлгэн өгсөн 52.2 км авто замын засвар арчлалтын ажлыг 2022.10.31-ны дотор хийж гүйцэтгэсэн" хэмээн баталгаат хугацааны засварын тайланг ирүүлсэн боловч хянан баталгаажуулаагүй байсан. Иймд нэхэмжлэгч нь баталгаат хугацааны засвар, арчлалтын тайланг концессын гэрээ, барилгын ажлын байнгын хяналтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу хянуулан ирүүлэхийг 2022.12.13-ны өдрийн 03/1547 дугаар албан бичгээр "Хос мөнгөн зам" ХХК-д мөн мэдэгдсэн.

Түүнчлэн үүссэн эвдрэлийг хүйтэн асфальт бетоноор засварласан боловч 2023 оны 5 дугаар сарын авто замын үзлэгээр хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахгүй байгаа нь тогтоогдсон тул яаралтай засварлуулахыг Зам, тээврийн хөгжлийн төв нь 2023.06.09-ны өдрийн 1/670 дугаар "Арга хэмжээ авах тухай" албан бичгийг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн бөгөөд хувийг "Ар Си Эс Си" ХХК болон "Хос мөнгөн зам" ХХК-д хүргүүлсэн байдаг.

Мөн хяналтын зөвлөх "Ар Си Эс Си" ХХК нь Хяргас нуур талаас 556-573 км-ийн хоорондох авто замын суурь, хучилтын засварыг технологийн дагуу гүйцэтгэхийг "Хос мөнгөн зам" ХХК-д удаа дараа мэдэгдсэн. Тухайлбал:

- 2023.07.26-ны өдрийн 137/23 дугаар албан бичгээр уг ажлыг 2023.09.01-ний өдрийн дотор дуусгахыг;
- 2023.09.05-ны өдрийн 176/23 дугаар албан бичгээр даалгасан хугацаа өнгөрсөн тул яаралтай гүйцэтгэхийг;
- 2024.05.01-ний өдрийн 116/24 дугаар албан бичгээр ажлын төлөвлөгөө, аргачлал, хүн хүч, машин механизм, үйлдвэрийн заводын талаарх бичиг баримтыг 2024.05.06-ны дотор ирүүлж баталгаажуулахыг;

- 2024.07.26-ны өдрийн 146/24 дугаар албан бичгээр мөн даалгасан хугацаа өнгөрсөн, баталгаат хугацаанд хэд хэдэн эвдрэл үүссэн тул засварын ажлыг дуусгахыг;
- 2024.09.17-ний өдрийн 178/24 дугаар албан бичгээр засварыг 2024.09.19-ний дотор гүйцэтгэхийг тус тус шаардсан.

Гэсэн хэдий ч “Хос мөнгөн зам” ХХК нь нэмэлт хугацаа өгсөн байгааг үл хүндэтгэн өнөөдрийг хүртэл засвар, арчлалтын ажлыг гүйцэтгээгүй бөгөөд гэрээний үүргээ зөрчсөн.

Хоёрдугаарт, Гэрээний үүргийг зөрчсөний улмаас хохирол учирсан тухай,

Монгол Улсын Иргэний хуулийн 219 дүгээр зүйлийн 219.1, 219.2, 352 дугаар зүйлийн 352.1 дэх хэсэгт дэх хэсэгт гэрээгээр хүлээсэн үүргээ талууд зохих ёсоор гүйцэтгээгүйгээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, үүргээ биелүүлэх нэмэлт хугацаанд үүргээ дахин биелүүлэхгүй бол учирсан хохирлоо арилгуулахаар шаардах эрхтэй байхаар хуульчилсан.

Авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдал, баталгаат хугацаанд хийгдсэн засвар арчлалтын ажлын гүйцэтгэлд 2023.09.09-ний өдөр төлөвлөгөөт шалгалтыг хийсэн. Тус хяналт шалгалтын хүрээнд гарсан 2023.09.20-ны өдрийн 04-00-02/007/65 дугаар Улсын ахлах байцаагчийн дүгнэлтээр тус замын ашиглалтын эрсдэлийг 40 хувь буюу “дунд” эрсдэлтэйгээр үнэлсэн бөгөөд засварыг гүйцэтгэхгүй бол цаашид эвдрэлийн хэмжээ нэмэгдэж, хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхээс гадна авто замын хэвийн ашиглалтад сөргөөр нөлөөлж, насжилтыг бууруулахад хүрнэ гэж дүгнэсэн.

Иймд 2023.09.20-ны өдрийн 04-00-02/007/184 дугаар “Илэрсэн дутагдлыг арилгуулах тухай” улсын ахлах байцаагчийн албан шаардлагаар Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.7 км хатуу хучилттай авто замын Хяргас нуур талаас 556 км-573 км хооронд гарсан эвдрэлийг дахин засварлах шаардлагатай бөгөөд замын ан цав гагнах ажил хийгдээгүй, босоо тэмдэг болон километрийн тэмдгийн наалт хууларсан, зарим тэмдэг байхгүй, анхааруулах шон хугарсан, нөхөн сэргээгүй, мөн авто замын суурь, хучилтад гарсан эвдрэлийг засварлах **нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж, чанарын хяналтын төлөвлөгөө, ажлын аргачлалын хамт зөвлөх байгууллагаар баталгаажуулаагүй** байгаа нь Автозамын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэг болон авто зам, замын байгууламжийн барилгын ажлын холбогдох шаардлагуудыг зөрсөн байх тул тус ажлуудыг хийж гүйцэтгэхийг “Хос мөнгөн зам” ХХК-д даалгасан.

“Хос мөнгөн зам” ХХК нь 2024.03.15-ны 24-03-15/2 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд Улсын ерөнхий байцаагчийн албан шаардлагын дагуу авто замын далан, суурь, хучилтын эвдрэлийг засварлах нарийвчилсан төлөвлөгөө, чанарын хяналтын төлөвлөгөө, засварын аргачлалыг боловсруулж, зөвлөх байгууллагаар **баталгаажуулан хүргүүлэхээ илэрхийлсэн**. Мөн үүний сацуу засварын ажлыг цаг агаарын тохиромжтой нөхцөлд, 2024 оны 2-р улиралд багтаан төслийн ерөнхий гүйцэтгэгч “Шинжиан Шинфа” ХХК-тай хамтран **гүйцэтгэхээ мэдэгдсэн**. Үүний дагуу 2024.06.17-ны 24-06-17 дугаар албан бичгээр “Завхан аймгийн Сонгино сумаас-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.7 км хатуу хучилттай авто замын **Км554+000-Км574+000** хооронд үүссэн эвдрэлийг засах

засварын ажлын календарчилсан график"-ийг боловсруулж, хяналтын зөвлөх "Ар Си Эс Си" ХХК-аар баталгаажуулан ирүүлсэн.

Гэсэн хэдийн ч 2024.08.09-ны өдрийн 03/1511 дугаар албан бичгээр нэхэмжлэгч нь "Баталгаат хугацааны засвар арчлалтын график төлөвлөгөө"-ний дагуу хийгдэж буй засвар арчлалтын тайлан мэдээллийг хяналтын зөвлөх компаниар хянуулан баталгаажуулж ирүүлэхийг, 2024.09.24-ний өдрийн 03/1906 дугаар албан бичгээр баталгаат хугацаанд хэд хэдэн эвдрэл үүссэн, засварын ажлыг дуусгахыг тус тус мэдэгдсэн боловч баталсан графикайнхаа дагуу хийж гүйцэтгэх ажлаа өнөөдрийг хүртэл хийгээгүй.

Түүнчлэн, Зам тээврийн сайдын 2024.09.12-ны өдрийн 01/648 дугаар, 2025.02.25-ны өдрийн 01/888 дугаар албан бичгүүдээр Завхан аймгийн Цагдаагийн газраас Завхан аймгийн Сонгино сумын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрдөг Сонгино сумаас-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.7 км хатуу хучилттай авто замын **Км554+000-Км574+000** хооронд үүссэн **эвдрэлийн улмаас** энэ оны 07, 08 дугаар саруудад ноцтой зам тээврийн ослууд бүртгэгдэж ослын улмаас 1 хүний амь нас хохирч, 6 хүний эрүүл мэндэд хохирол учирсан тул авто замын эвдрэлийг яаралтай засварлуулах шаардлага хүргүүлсэн.

Тус шаардлагын дагуу Зам, тээврийн хөгжлийн яамнаас зам хариуцагч, хяналтын зөвлөх "Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-т чиглэл өгч, засварын ажлын төсвийг гаргуулсны үндсэн дээр улсын чанартай авто замд гарсан гэнэтийн эвдрэлийг засварлах онцгой ажлын зардлаас 180.14 сая төгрөгөөр санхүүжүүлэн² замын хучилтад үүссэн нүхэн эвдрэлийг цементээр бэхжүүлсэн шороон материалаар нөхөх хүйтний улиралд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах түр арга хэмжээ авсныг мэдэгдсэн бөгөөд цаашид норм норматив, техникийн шаардлагын дагуу хучилтад үүссэн эвдрэлийг хэсэгчлэн болон тодорхой уртад суурийг хүчитгэх, халуун асфальтбетоноор засварлах арга хэмжээ шуурхай авч хэрэгжүүлэхгүй бол хөдөлгөөний аюулгүй байдал алдагдахаас гадна эвдрэлийн хэмжээ болон засварын ажлын зардал эрс нэмэгдэх нөхцөл байдал үүсээд байгаа мэдээллийг ирүүлсэн.

Дээрх нөхцөл байдлуудаас "Хос мөнгөн зам" ХХК-аас өөр гүйцэтгэгчээр авто замын засварын ажлыг хийлгэхэд шаардлагатай санхүүжилтийг бүрдүүлэх, авто замын суурь, хучилтад гарсан эвдрэлийг яаралтай засварлаж, хөдөлгөөний аюулгүй байдлыг яаралтай хангуулах шаардлага тулгарч байна.

Иймд Иргэний хуулийн 219 дүгээр зүйлийн 219.1, 219.2, 352 дугаар зүйлийн 352.1 дэх хэсэг, 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн барих-шилжүүлэх (ВТ) концессын гэрээний 1.8, 1.10, 2.21 дэх хэсэгт тус тус заасны дагуу авто замын баталгаат хугацаанд үүссэн эвдрэлийн улмаас хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах түр арга хэмжээнд зарцуулагдсан 180,139,486.00 (нэг зуун наян сая нэг зуун гучин есөн мянга дөрвөн зуун наян зургаа) төгрөг болон авто

²Зам тээврийн хөгжлийн сайдын 2024 оны А/252 дугаар "Улсын чанартай авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэлийг сэргээн засварлах хөрөнгийн жагсаалт батлах тухай" тушаалын хавсралтын 14 дэх хэсэгт 180,139,486.00 (нэг зуун наян сая нэг зуун гучин есөн мянга дөрвөн зуун наян зургаа) төгрөг байхаар баталж "А18 дугаартай Нөмрөг-Сонгино-Наранбулаг чиглэлийн 553-573 км хатуу хучилттай авто замын хучилтын нүхэн эвдрэлийг засварлах онцгой ажил"-ийн төсвийг мөн дүнгээр Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.10.31-ны өдөр баталсан.

замын баталгаат хугацаанд гарсан эвдрэлийг засварлах ажлын зардал зардал(хохирол)-ыг концесс эзэмшигчээс гаргуулж өгнө үү.

Хэргийг хянан шийдвэрлэх харьяаллын хувьд буюу арбитрын хэлэлцээрийн тухайд:

Монгол Улсын Засгийн газар "Хос мөнгөн зам" ХХК-ийн хооронд байгуулсан "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн барих-шилжүүлэх (ВТ) концессын гэрээний 7 дугаар зүйлд "Талууд маргааныг энэхүү Гэрээний 7.2-т зааснаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Арбитрын шүүхэд гомдол гаргах замаар шийдвэрлүүлнэ." гэж тохиролцсоны дагуу тус маргааныг шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргасан болохыг дурдаж байна.

Нэхэмжлэлд дараах баримтуудыг хавсарган хүргүүлж байна:

1. Итгэмжлэл – 1% /эх хувь/;
2. Арбитрын үндсэн зардлыг төлсөн баримт – 1%/эх хувь/;
3. Улсын Их Хурлын 2009 оны "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай" 64 дугаар тогтоол – 1 хуудас;
4. Засгийн газрын 2013 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай" 317 дугаар тогтоол – 1 хуудас;
5. Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 213 дугаар тогтоол – 1 хуудас;
6. Засгийн газрын хуралдааны 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 63 дугаар тэмдэглэл- 2 хуудас;
7. Засгийн газрын 2016 оны 38 дугаар тогтоолоор– 1 хуудас;
8. Засгийн газрын 2022 оны 14 дүгээр тогтоолоор– 1 хуудас;
9. 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль– 2 хуудас;
10. Засгийн газрын 2022 оны 12 дугаар тогтоолын хавсралт Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр– 12 хуудас;
11. Засгийн газрын 2024 оны 06 дугаар тогтоол – 13 хуудас;
12. 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн барих-шилжүүлэх (ВТ) концессын гэрээ– 13 хуудас;
13. 2017 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн байгуулсан "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ– 1 хуудас;
14. 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн байгуулсан "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ– 1 хуудас;
15. 2018 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн байгуулсан "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ–1 хуудас;
16. 2019 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн байгуулсан "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ–1 хуудас;

17. Үндэсний хөгжлийн газар болон "Ар Си Эс Си" ХХК-ийн хооронд 2017 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр байгуулагдсан "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төслийн барилгын ажлын байнгын хяналтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээ" –19 хуудастай;
18. 2019.01.30-ны өдрийн 07/15/18 дугаар "Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах ажлын хэсгийн дүгнэлт болон хуралдааны тэмдэглэл, ажлын хэсгийн акт" –15 хуудастай;
19. 2019.12.27-ны өдрийн 10/18/19 дугаар "Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах ажлын хэсгийн дүгнэлт болон хуралдааны тэмдэглэл, ажлын хэсгийн акт" –17 хуудастай;
20. Зам тээврийн хөгжлийн яамнаас Эдийн засаг, хөгжлийн яаманд 2022.09.13-ны өдөр хүргүүлсэн 03/4162 дугаар "Гэрээний хэрэгжилт хангуулах тухай" албан бичиг, хавсралт–2 хуудастай;
21. Эдийн засаг, хөгжлийн яамнаас "Хос мөнгөн зам" ХХК-д 2022.09.27-ны өдөр хүргүүлсэн 03/1071 дугаар "Хэрэгжилт ирүүлэх тухай" албан бичиг–1 хуудастай;
22. "Ар Си Эс Си" ХХК-аас Эдийн засаг, хөгжлийн яаманд 2022.11.21-ны өдөр ирүүлсэн 242/22 дугаар албан бичиг – 1 хуудастай;
23. Эдийн засаг, хөгжлийн яамнаас "Хос мөнгөн зам" ХХК-д 2022.12.13-ны өдөр хүргүүлсэн "хэрэгжилт ирүүлэх тухай" 03/1547 дугаар албан бичиг–1 хуудастай;
24. "Ар Си Эс Си" ХХК-аас "Хос мөнгөн зам" ХХК-д 2024.09.17-ны өдөр хүргүүлсэн "Мэдэгдэл хүргүүлэх тухай" 178/24 дугаар албан бичиг–1 хуудастай;
25. Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2023.10.02-ны өдөр хүргүүлсэн "Шалгалтын дагуу авах арга хэмжээний тухай" 13/4644 дугаар албан бичиг, хавсралт–8 хуудастай;
26. "Хос мөнгөн зам" ХХК нь Зам, тээврийн хөгжлийн яаманд 2024.03.15-ны өдөр хүргүүлсэн "Засвар арчлалтын тухай" 24-03-15/2 дугаар албан бичиг–1 хуудастай;
27. "Хос мөнгөн зам" ХХК нь Эдийн засаг, хөгжлийн яаманд 2024.06.17-ны өдөр хүргүүлсэн "Засвар арчлалтын тухай" 24-06-17 дугаар албан бичиг –2 хуудастай;
28. Эдийн засаг, хөгжлийн яамнаас "Хос мөнгөн зам" ХХК-д 2024.08.09-ны өдөр хүргүүлсэн "Тайлан ирүүлэх тухай" 03/1511 дугаар албан бичиг –1 хуудастай;
29. Эдийн засаг, хөгжлийн яамнаас "Хос мөнгөн зам" ХХК-д 2024.03.20-ны өдөр хүргүүлсэн "Мэдэгдэл хүргүүлэх тухай" 03/552 дугаар албан бичиг –1 хуудастай;
30. Эдийн засаг, хөгжлийн яамнаас "Хос мөнгөн зам" ХХК-д 2023.10.05-ны өдөр хүргүүлсэн "Албан шаардлага хүргүүлэх тухай" 07/1846 дугаар албан бичиг, хавсралт – 17 хуудастай;
31. Зам, тээврийн сайдаас Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 2024.09.12-ны өдөр хүргүүлсэн "Авто замын эвдрэлийг засварлуулах тухай" 01/648 дугаар албан бичиг, хавсралт– 7 хуудастай;
32. Зам, тээврийн сайдаас Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 2025.02.25-ны өдөр хүргүүлсэн "Авто замын эвдрэлийн талаар" 01/888 дугаар албан бичиг, хавсралт– 15 хуудастай;

33. Эдийн засаг, хөгжлийн яамнаас "Хос мөнгөн зам" ХХК-д 2024.09.24-ны өдөр хүргүүлсэн "Хариу хүргүүлэх тухай" 03/1906 дугаар албан бичиг– 1 хуудастай;

Жич: хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хяналтын зөвлөх "Ар Си Эс Си" ХХК-аас "Хос мөнгөн зам" ХХК-д хүргүүлж байсан албан шаардлага, бичгүүдийг нотлох баримтын шаардлага хангуулан гаргуулах хүсэлтэй байна.

Нийт.... хуудастай баримт.

Нэхэмжлэл гаргасан:

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ
ХӨГЖЛИЙН САЙД



Л.ГАНТӨМӨР



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
САЙД Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrtf.gov.mn,
Цахим хуудас: www.mrtf.gov.mn

2024.06.07 № 01/2534
танай _____ -НБ № _____ -Т

Шуурхай арга хэмжээ авах тухай


Концессын "барих-шилжүүлэх" гэрээгээр хэрэгжиж 2019 онд ашиглалтад орсон "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам" төслийн чанарын баталгаат хугацаанд гарсан технологийн эвдрэлүүдийг цаг тухай бүр норм, дүрэм, техникийн шаардлагын дагуу засварлаагүйн улмаас авто замын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдал алдагдаж, тухайн чиглэлийн авто замаар зорчиж буй жолооч тээвэрчид, аялагч жуулчид болон Увс аймгийн иргэд эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирч байгаа тул замын эвдрэлийг засварлуулах, концессын гэрээний хэрэгжилтийг хангуулах, хариуцлага тооцуулах талаар эрх бүхий этгээдийн хувиар танай яаманд удаа дараа албан бичиг хүргүүлсэн.

Зам, тээврийн яамны зүгээс баталгаат хугацаанд замд үүссэн технологийн эвдрэлийг засварлах талаар концесс эзэмшигч "Хос мөнгөн зам" ХХК болон зөвлөх "Ар Си Эс Си" ХХК-д албан бичгээр мэдэгдэл, Улсын байцаагчийн албан шаардлагууд хүргүүлж, хурал, талбайн уулзалтууд зохион байгуулж ажилласан.

Тухайлбал, 2024 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр төслийн ажлын талбайд буюу Завхан аймгийн Сонгино суманд Зам, тээврийн хөгжлийн яам, концесс эзэмшигч, зөвлөх, "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын төлөөллийг оролцуулсан хурал зохион байгуулсан бөгөөд уг хурлаар болон 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 24-04-18 тоот албан бичгээр концесс эзэмшигч нь замын засварын ажлыг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор бүрэн дуусгах амлалт өгсөн боловч өнөөдрийн байдлаар ажил хийгдээгүй, ямар нэгэн хүн хүч, тоног төхөөрөмж байршуулаагүй байна.


Иймд эрх бүхий этгээдийн хувьд гэрээний үүргээ биелүүлээгүй концесс эзэмшигч "Хос мөнгөн зам" ХХК-ийг хууль, хяналтын байгууллагад өгч, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах, концессын гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй ажлын зардлыг концесс эзэмшигчээс гаргуулах, замын засварын ажлыг хугацаа алдалгүй гүйцэтгүүлэх арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг хүсье.

Хавсралт 1. хуудастай.



С.БЯМБАЦОГТ

0000000047



Боловсруулсан: *А. Доржиев*

Хянасан:

Хувь: *2*

Огноо: *2021.06.06*



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 71 08, Факс: (976-11) 31 23 16,
Цахим шуудан: info@mrtid.gov.mn,
Цахим хуудас: www.mrtid.gov.mn

2024-03-07 № 01/981
танай _____ -ийн № _____ -т

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
САЙД Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА**

Арга хэмжээ авах тухай


Концессын гэрээгээр хэрэгжиж буй төслүүдийн хувьд гэрээний тал болох Эдийн засаг, хөгжлийн яам нь концессын гэрээний хэрэгжилтийг хангуулах эрх, үүргийг хүлээн ажиллаж байгаа билээ.

Сүүлийн үед улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын "Барих-шилжүүлэх" гэрээгээр хэрэгжсэн зарим авто замын төслүүдийн концесс эзэмшигч нь Авто замын тухай хууль болон концессын гэрээнд заасан чанарын баталгаат хугацаанд үүссэн технологийн эвдрэлийг тухай бүр норм, норматив, техникийн шаардлагын дагуу засварлаагүйн улмаас авто замын бэлэн байдал болон тээврийн хэрэгслийн аюулгүй зорчих нөхцөл алдагдаад байна.

Тухайлбал, концессын гэрээгээр хэрэгжиж 2019 оны 12 дугаар сард ашиглалтад оруулсан Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам дээр 2021, 2022 онд чанарын баталгаат хугацаанд гарсан эвдрэлүүдийг засварлуулахаар тус яамнаас концесс эзэмшигчид улсын байцаагчийн шаардлага хүргүүлж, мөн гэрээний хэрэгжилтийг хангуулах, хариуцлага тооцуулах талаар танай яаманд удаа дараа албан бичгээр хандсан боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Иймд эрх бүхий этгээдийн хувьд гэрээний үүргээ биелүүлээгүй, ноцтой зөрчсөн концесс эзэмшигч нарт гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, концессын гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй ажлын зардлыг концесс эзэмшигчид төлөх эргэн төлөлтөөс суутган авч, дараагийн мэргэжлийн байгууллагыг сонгон замын засварын ажлыг хугацаа алдалгүй гүйцэтгүүлж, гэрээний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг нэн даруй авч байхыг хүсье.

Баталгаат хугацаанд авто замд үүссэн технологийн эвдрэлийг шаардлага хангасан хэмжээнд засварлуулж, холбогдох журмын дагуу баталгаажуулаагүй тохиолдолд тухайн авто замыг хүлээн авах боломжгүйг үүгээр мэдэгдэж байна.



080000237



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251

Утас: (976-51) 26 71 68, Факс: (976-11) 31 23 15,

Цахим шуудан: info@mrid.gov.mn,

Цахим хуудас: www.mrid.gov.mn

1020-10-000 № 01/4601
танай _____-ны № _____-г

Хамтран ажиллах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 213 дугаар тогтоолын дагуу "Хос мөнгөн зам" ХХК нь концессын гэрээ байгуулан, "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам"-ыг барьж, 2019 онд байнгын ашиглалтад оруулсан.

Тус авто замын Хяргас нуур талаас 556-573 км хоорондох авто замын суурь болон хучилтын технологийн эвдрэлийг 2022 оны 11 дүгээр сарын 13-15-ны өдрүүдэд хүйтэн асфальтбетон хольцоор засварласан боловч 2023 оны 05 дугаар сард дахин эвдрэл гарч, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахгүй нөхцөл байдал үүсээд байна.

Тус яамнаас 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 06/3004 тоот албан бичгээр зөвлөх "Ар Си Эс Си" ХХК-д концессын гэрээний 4.10-д "Зөвлөх чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг концесс эзэмшигчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил доголдлыг арилгаж дуусах хүртэл хугацаагаар сунгана", 4.11-д "Зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр концесс эзэмшигч уг зөрчил, доголдлыг Зөвлөхийн мэдэлд заасан хугацаанд багтааж концесс эзэмшигч өөрийн зардлаар арилгана" гэж заасны дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, ажлын дүнгийн талаар мэдэгдэх тухай шаардлага хүргүүлсэн.

Мөн Төрийн нарийн бичгийн даргаас ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 03/3597 тоот албан бичгээр тус авто замд гарсан эвдрэлийг засварлаж, баталгаажуулаагүй тохиолдолд тухайн авто замыг хүлээн авах боломжгүй талаар мэдэгдсэн.

Гүйцэтгэгч "Хос мөнгөн зам" ХХК-д тус авто замын суурь болон хучилтад гарсан эвдрэлийг технологийн дагуу засварлах талаар танай яамнаас 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 08/1503, зөвлөх "Ар Си Эс Си" ХХК-иас 2023 оны 07 дугаар сарын 26-ны 137/23, 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 176/23 тоот албан бичгээр тус тус шаардлага хүргүүлсэн байна.

Гэвч, тус авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэлүүдийн засварын ажлыг цаг хугацаанд нь технологийн шаардлагын түвшинд гүйцэтгээгүйгээс Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дах "Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын гүйцэтгэгч нь батлагдсан зураг төсөл, норм, норматив, техникийн баримт бичиг, техник, технологи, эрүүл ахуй, байгаль орчны болон замын хөдөлгөөний аюулгүй

0300-1828

байдлын шаардлагыг биелүүлэх үүрэгтэй" гэсэн заалтын хэрэгжилт бүрэн хангагдахгүй нөхцөл байдал үүсээд байна.


Гүйцэтгэгч байгууллага батлагдсан зураг төсөл, техникийн шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаагүйгээс авто замын зорчих хэсэгт үүссэн торон хагарал, суурийн эвдрэл гарч байгаа хэсэгт эвдрэлийн шалтгааныг тогтоож, тохирсон засварыг гүйцэтгүүлэхгүй бол цаашид эвдрэлийн хэмжээ нэмэгдэж, хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхээс гадна авто замын хэвийн ашиглалтад сөргөөр нөлөөлж, насжилтыг бууруулах эрсдэлтэй байна.

ЭЗХЯ Захиалагчийг төлөөлж "Хос мөнгөн зам" ХХК-тай "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн гэрээ байгуулсны хувьд барих-шилжүүлэх (ВТ) концессын гэрээг дүгнэж, гэрээний 4.10, 4.11 болон бусад заалтын хэрэгжилтийг хууль тогтоомж, батлагдсан зураг төсөл, стандарт, норм норматив, дүрэм журам, техникийн нөхцөл шаардлагыг хангуулан авто замын хэвийн ашиглалтын байдлыг бүрдүүлж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдалд нийцүүлэх нь зүйтэй байна.

Цаашид баталгаат хугацааны явцад үүссэн технологийн эвдрэлүүдийг яаралтай засварлаагүй, авто замын ашиглалтын бэлэн байдлыг хангахгүй байгаа нь гэрээний үүргээ ноцтой зөрчиж байгаа гэж үзэн зөвлөх "Ар Си Эс Си" ХХК болон гүйцэтгэгч "Хос мөнгөн зам" ХХК-ийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д заасны дагуу холбогдох арга хэмжээг авч, хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт: ...1 хуудастай.

Хувийг: "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ,
"Ар Си Эс Си" ХХК,
"Хос мөнгөн зам" ХХК,
"Завхан-АЗЗА" ТӨХК-д.





ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА И.БАТХҮҮ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251

Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,

Цахим шуудан: info@mrd.gov.mn,

Цахим хуудас: www.mrd.gov.mn

АЛС. 11-д8 № 03/5659
танай АЛС. 10-31-ны № 03/6012 -т

"Хос мөнгөн зам" ХХК-ийн концессын "Барих-шилжүүлэх" гэрээгээр хэрэгжүүлсэн "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам"-ын ашиглалтын байдал, засвар арчлалтын ажилд хийсэн үзлэг, шалгалт, өгсөн үүрэг даалгаврууд, тэдгээрийн хэрэгжилттэй холбоотой баримт, материалыг хавсралтаар хүргүүлж байна.

Чанарын баталгаат хугацаанд үүссэн технологийн эвдрэл гэмтлийг тухай бүр норм, дүрэм, техникийн шаардлагын хэмжээнд засварлаагүйн улмаас авто замын ашиглалтын бэлэн байдал алдагдаж, авто замаар зорчих иргэдийн амь нас, эд хөрөнгө хохирох эрсдэлтэй нөхцөл байдал үүсээд байгаа бөгөөд авто замд гарсан технологийн эвдрэлийг шаардлага хангасан хэмжээнд засварлаж, баталгаажуулаагүй тохиолдолд тухайн авто замыг хүлээн авах боломжгүйг талаар 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 03/3597 тоот албан бичгээр мөн Танд хүргүүлсэн.

Хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчаас тухай бүр холбогдох норм дүрмийн дагуу далан, суурь, хучилтыг засварлах нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, аргачлалыг боловсруулан баталгаажуулсны үндсэн дээр гүйцэтгэх шаардлага хүргүүлж байсан боловч биелүүлээгүй байна.

Иймд гэрээний үүргээ нөхцөйл зөрчсөн концесс эзэмшигч "Хос мөнгөн зам" ХХК-д гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээг авч, хариуцлага хүлээлгэн, авто замын эвдрэлийг шаардлага хангасан хэмжээнд засварлуулж, ард иргэдийнхээ аюул осолгүй, тав тухтай зорчих нөхцөлийг хангахад хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт: ... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА
С.БАТБОЛД

0303 8791



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 17,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79; Факс: (976-11) 31 23 15;
Цахим шуудан: info@mrt.gov.mn;
Цахим хуудас: www.mrt.gov.mn

2024-09-12 № 01/648
Танайг _____-ны № _____-т

**Авто замын эвдрэлийг засварлуулах
тухай**

Завхан аймгийн Цагдаагийн газраас концессын "барих-шилжүүлэх" гэрээгээр хэрэгжсэн Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто замын 554-574 км хооронд үүссэн эвдрэлийг яаралтай засварлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүсэлт ирүүлснийг чиг үүргийн дагуу Танд уламжилж байна.

Энэхүү төслийн чанарын баталгаат хугацаанд гарсан технологийн эвдрэлүүдийг Авто замын тухай хууль болон концессын гэрээний дагуу засварлуулах, концессын гэрээний хэрэгжилтийг хангуулах, хариуцлага тооцуулах талаар эрх бүхий этгээдийн хувиар танай яаманд удаа дараа албан бичиг хүргүүлсэн.

Авто замд үүссэн эвдрэлийг цаг тухай бүр норм, дүрэм, техникийн шаардлагын дагуу засварлаагүйн улмаас авто замын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдал алдагдаж, тухайн чиглэлийн авто замаар зорчиж буй жолооч тээвэрчид, аялагч жуулчид болон ард иргэд амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирч болзошгүй нөхцөл байдал үүсээд байгааг мэдэгдэж байсан. Гэвч одоог хүртэл тодорхой арга хэмжээ авч ажиллаагүйн улмаас зам тээврийн ноцтой ослууд гарсан талаар Завхан аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн албан бичигт дурдсан байна.

Зам, тээврийн яамны зүгээс чанарын баталгаат хугацаанд замд үүссэн технологийн эвдрэлийг засварлах талаар концесс эзэмшигч "Хос мөнгөн зам" ХХК болон зөвлөх "Ар Си Эс Си" ХХК-д албан бичгээр мэдэгдэл, Улсын байцаагчийн албан шаардлагууд хүргүүлж, хурал, талбайн уулзалтууд зохион байгуулж ажилласан.

Концесс эзэмшигч нь 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 24-04-18 тоот албан бичгээр замын засварын ажлыг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор бүрэн дуусгах амлалт өгсөн боловч өнөөдрийн хүртэл ажил хийгдээгүй, ямар нэгэн хүн хүч, тоног төхөөрөмж байршуулаагүй байна.

Иймд гэрээний үүргээ биелүүлэхгүй байгаа концесс эзэмшигч "Хос мөнгөн зам" ХХК-ийг хууль, хяналтын байгууллагад өгч хариуцлага тооцуулах, концессын


030021150

02110550

гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй ажлын зардлыг концесс эзэмшигчээс гаргуулах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг хүсье.

Хавсралт ... хуудастай.

Хувийг: Завхан аймгийн Цагдаагийн газрын дарга Дэд хурандаа
Н.Отгонжаргалд



Б.ДЭЛГЭРСАЙХАН



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
"АЛТАН ГАДАС" ОДОНТ
ЦАГДААГИЙН ГАЗАР**

Улсаас 7040-2220 Факс: 7040-2220
Web: www.zavkhan-pavement.mn

2024 08 14 № 41/3071
танил -т

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМАНД**

Замын эвдрэлийг засварлуулах тухай


Тус аймгийн Сонгино сумын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрдөг Улсын чанартай А18 дугаартай Сонгино сумаас-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.7 км хатуу хучилттай авто замын КМ554+000-КМ574+000 хооронд үүссэн эвдрэлийн улмаас энэ оны 07, 08 дугаар саруудад ноцтой зам тээврийн ослууд бүртгэгдэж ослын улмаас 1 хүний амь хохирч, 6 хүний эрүүл мэндэд хохирол учирсан.

Уг замын эвдрэлийг засуулах чиглэлээр зам арчлалт хариуцсан "Завхан АЗЗА" ТӨХК-д мэдэгдэл, шаардлага хүргүүлсэн боловч Зам, тээврийн хөгжлийн яамнаас "Хос мөнгөн зам" ХХК-аар засварлуулах чиглэл өгсөн тул манай байгууллага засварлах боломжгүй гэсэн хариуг ирүүлсэн.

Иймд тухайн замыг харицсан аж ахуйн, нэгж байгууллагаар замын эвдрэл гэмтлийг яаралтай засварлуулах арга хэмжээг зохион байгуулан хариуг ирүүлнэ үү.




Замын эвдрэлийн зургийг хавсаргав.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА



Н.ОТГОНЖАРГАЛ

8146000221





МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
САЙД Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

Засгийн газрын XIII байр, Чингисийн оргон чөлөө 11,

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251

Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,

Цахим шуудан: info@mrid.gov.mn,

Цахим хуудас: www.mrid.gov.mn

2024.06.07 № 01/02534

танай _____-ны № _____-т

Шуурхай арга хэмжээ авах тухай


Концессын "барих-шилжүүлэх" гэрээгээр хэрэгжиж 2019 онд ашиглалтад орсон "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам" төслийн чанарын баталгаат хугацаанд гарсан технологийн эвдрэлүүдийг цаг тухай бүр норм, дүрэм, техникийн шаардлагын дагуу засварлаагүйн улмаас авто замын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдал алдагдаж, тухайн чиглэлийн авто замаар зорчиж буй жолооч тээвэрчид, аялагч жуулчид болон Увс аймгийн иргэд эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирч байгаа тул замын эвдрэлийг засварлуулах, концессын гэрээний хэрэгжилтийг хангуулах, хариуцлага тооцуулах талаар эрх бүхий этгээдийн хувиар танай яаманд удаа дараа албан бичиг хүргүүлсэн.

Зам, тээврийн яамны зүгээс баталгаат хугацаанд замд үүссэн технологийн эвдрэлийг засварлах талаар концесс эзэмшигч "Хос мөнгөн зам" ХХК болон зөвлөх "Ар Си Эс Си" ХХК-д албан бичгээр мэдэгдэл, Улсын байцаагчийн албан шаардлагууд хүргүүлж, хурал, талбайн уулзалтууд зохион байгуулж ажилласан.

Тухайлбал, 2024 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр төслийн ажлын талбайд буюу Завхан аймгийн Сонгино суманд Зам, тээврийн хөгжлийн яам, концесс эзэмшигч, зөвлөх, "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын төлөөллийг оролцуулсан хурал зохион байгуулсан бөгөөд уг хурлаар болон 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 24-04-18 тоот албан бичгээр концесс эзэмшигч нь замын засварын ажлыг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор бүрэн дуусгах амлалт өгсөн боловч өнөөдрийн байдлаар ажил хийгдээгүй, ямар нэгэн хүн хүч, тоног төхөөрөмж байршуулаагүй байна.

Иймд эрх бүхий этгээдийн хувьд гэрээний үүргээ биелүүлээгүй концесс эзэмшигч "Хос мөнгөн зам" ХХК-ийг хууль, хяналтын байгууллагад өгч, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах, концессын гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй ажлын зардлыг концесс эзэмшигчээс гаргуулах, замын засварын ажлыг хугацаа алдалгүй гүйцэтгүүлэх арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг хүсье.

Хавсралт  хуудастай.



С.БЯМБАЦОГТ



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11.

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251

Утас: (976-51) 26 71 68, Факс: (976-11) 31 23 16,

Цахим шуудан: info@mrid.gov.mn,

Цахим хуудас: www.mrid.gov.mn

10244-03-07 № 01/981
танай _____ -ийн № _____ -т

Арга хэмжээ авах тухай

Концессын гэрээгээр хэрэгжиж буй төслүүдийн хувьд гэрээний тал болох Эдийн засаг, хөгжлийн яам нь концессын гэрээний хэрэгжилтийг хангуулах эрх, үүргийг хүлээн ажиллаж байгаа билээ.

Сүүлийн үед улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын "Барих-шилжүүлэх" гэрээгээр хэрэгжсэн зарим авто замын төслүүдийн концесс эзэмшигч нь Авто замын тухай хууль болон концессын гэрээнд заасан чанарын баталгаат хугацаанд үүссэн технологийн эвдрэлийг тухай бүр норм, норматив, техникийн шаардлагын дагуу засварлаагүйн улмаас авто замын бэлэн байдал болон тээврийн хэрэгслийн аюулгүй зорчих нөхцөл алдагдаад байна.

Тухайлбал, концессын гэрээгээр хэрэгжиж 2019 оны 12 дугаар сард ашиглалтад оруулсан Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам дээр 2021, 2022 онд чанарын баталгаат хугацаанд гарсан эвдрэлүүдийг засварлуулахаар тус яамнаас концесс эзэмшигчид улсын байцаагчийн шаардлага хүргүүлж, мөн гэрээний хэрэгжилтийг хангуулах, хариуцлага тооцуулах талаар танай яаманд удаа дараа албан бичгээр хандсан боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Иймд эрх бүхий этгээдийн хувьд гэрээний үүргээ биелүүлээгүй, ноцтой зөрчсөн концесс эзэмшигч нарт гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, концессын гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй ажлын зардлыг концесс эзэмшигчид төлөх эргэн төлөлтөөс суутган авч, дараагийн мэргэжлийн байгууллагыг сонгон замын засварын ажлыг хугацаа алдалгүй гүйцэтгүүлж, гэрээний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг нэн даруй авч байхыг хүсье.

Баталгаат хугацаанд авто замд үүссэн технологийн эвдрэлийг шаардлага хангасан хэмжээнд засварлуулж, холбогдох журмын дагуу баталгаажуулаагүй тохиолдолд тухайн авто замыг хүлээн авах боломжгүйг үүгээр мэдэгдэж байна.

С.БЯМБАЦОГТ

0300002.7



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА И.БАТХҮҮ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251

Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,

Цахим шуудан: info@mrid.gov.mn

Цахим хуудас: www.mrid.gov.mn

МЗС. 11-28 № 03/5659
танай МЗС. 10-31 -ны № 03/6012 -т

"Хос мөнгөн зам" ХХК-ийн концессын "Барих-шилжүүлэх" гэрээгээр хэрэгжүүлсэн "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам"-ын ашиглалтын байдал, засвар арчлалтын ажилд хийсэн үзлэг, шалгалт, өгсөн үүрэг даалгаврууд, тэдгээрийн хэрэгжилттэй холбоотой баримт, материалыг хавсралтаар хүргүүлж байна.

Чанарын баталгаат хугацаанд үүссэн технологийн эвдрэл гэмтлийг тухай бүр норм, дүрэм, техникийн шаардлагын хэмжээнд засварлаагүйн улмаас авто замын ашиглалтын бэлэн байдал алдагдаж, авто замаар зорчих иргэдийн амь нас, эд хөрөнгө хохирох эрсдэлтэй нөхцөл байдал үүсээд байгаа бөгөөд авто замд гарсан технологийн эвдрэлийг шаардлага хангасан хэмжээнд засварлаж, баталгаажуулаагүй тохиолдолд тухайн авто замыг хүлээн авах боломжгүйг талаар 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 03/3597 тоот албан бичгээр мөн Танд хүргүүлсэн.

Хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчаас тухай бүр холбогдох норм дүрмийн дагуу далан, суурь, хучилтыг засварлах нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, аргачлалыг боловсруулан баталгаажуулсны үндсэн дээр гүйцэтгэх шаардлага хүргүүлж байсан боловч биелүүлээгүй байна.

Иймд гэрээний үүргээ ноцтой зөрчсөн концесс эзэмшигч "Хос мөнгөн зам" ХХК-д гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээг авч, хариуцлага хүлээлгэн, авто замын эвдрэлийг шаардлага хангасан хэмжээнд засварлуулж, ард иргэдийнхээ аюул осолгүй, тав тухтай зорчих нөхцөлийг хангахад хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт: ... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

С.БАТБОЛД

0309 0701



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө-11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mnt.gov.mn,
Цахим хуудас: www.mnt.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД Л.ГАНТӨМӨР
ТАНАА

2025.02.25 01/888

танай _____ -ныг _____

Авто замын эвдрэлийн талаар

Концессын "барих-шилжүүлэх" гэрээгээр хэрэгжиж 2019 онд ашиглалтад орсон "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам" төслийн чанарын баталгаат хугацаанд гарсан технологийн эвдрэлүүдийг цаг тухай бүр норм, дүрэм, техникийн шаардлагын дагуу засварлаагүйн улмаас авто замын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдал алдагдаж, тухайн чиглэлийн авто замаар зорчиж буй жолооч тээвэрчид, аялагч жуулчид, иргэд эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирч байгаа тул замын эвдрэлийг засварлуулах, концессын гэрээний хэрэгжилтийг хангуулах, хууль хяналтын байгууллагад хандаж хохирлыг барагдуулах, хариуцлага тооцуулах, концессын гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй ажлын зардлыг концесс эзэмшигчээс гаргуулах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх талаар танай яаманд удаа дараа албан бичиг хүргүүлсэн.

Завхан аймгийн Цагдаагийн газраас "Замын эвдрэлийг засварлуулах тухай" 2024 оны 41/3071 дугаартай албан бичгээр тухайн авто замын 554-574 км хооронд үүссэн эвдрэлийн улмаас 7, 8 дугаар саруудад ноцтой зам тээврийн ослоуд бүртгэгдэж, ослын улмаас 1 хүний амь хохирч, 6 хүний эрүүл мэндэд хохирол учирсан тул уг замын эвдрэлийг яаралтай засварлуулах шаардлага ирүүлсний дагуу тус яамнаас зам хариуцагч, хяналтын зөвлөх "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-т чиглэл өгч, засварын ажлын төсвийг гаргуулсны үндсэн дээр улсын чанартай авто замд гарсан гэнэтийн эвдрэлийг засварлах онцгой ажлын зардлаас 180.14 сая төгрөгөөр санхүүжүүлэн замын хучилтад үүссэн нүхэн эвдрэлийг цементээр бэхжүүлсэн шороон материалаар нөхөх хүйтний улиралд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах түр арга хэмжээ авсан.

Цаашид норм норматив, техникийн шаардлагын дагуу хучилтад үүссэн эвдрэлийг хэсэгчлэн болон тодорхой уртад суурийг хүчитгэх, халуун асфальтбетоноор засварлах арга хэмжээ шуурхай авч хэрэгжүүлэхгүй бол хөдөлгөөний аюулгүй байдал алдагдахаас гадна эвдрэлийн хэмжээ болон засварын ажлын зардал эрс нэмэгдэх нөхцөл байдал үүсээд байна.

Иймд концессын гэрээнд заасны дагуу чанарын баталгаат хугацаанд гарсан технологийн эвдрэлийг засварлах ажлын зардлыг концесс эзэмшигчээс гаргуулах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг хүсье.

Хавсралт 14 хуудастай.



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
УДИРДЛАГА
САЙД
Б.ДЭЛГЭРСАЙХАН
2025.02.25 13:00

680021454



**МОНГОЛ
ЗАМ, ТЭЭВЭР**

Засгийн газрын XIII байр,
Сүхбаатар дүүрэг, Уг
Утас: (978-51) 28 31 79, Факс: (978-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrt.gov.mn,
Цахим хуудас: www.mrt.gov.mn

5052'01'52 50:08
P'ᠲᠡᠨᠭᠡᠨᠭᠡᠨᠭᠡᠨ
Cᠡᠨᠭᠡ
᠕ᠲᠡᠨᠭᠡᠨᠭᠡᠨᠭᠡᠨ
3᠑᠕ᠮ' 1ᠡᠡᠪᠦᠨᠭᠡᠨᠭᠡᠨᠭᠡᠨ

ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД
Н.УЧРАЛ ТАНАА

2025.07.25 № 01/3403

танай _____-ны № _____-т

Авто замын эвдрэлийн талаар

“Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам” нь концессын “барих-шилжүүлэх” нөхцөлтэй гэрээгээр хэрэгжиж, 2019 онд ашиглалтад орсон билээ.

Гэвч тус авто замын 553-573 км-ийн хооронд чанарын баталгаат хугацаанд технологийн эвдрэл үүссэн нь Авто замын хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр тогтоогдсон бөгөөд энэхүү эвдрэлийг арилгуулах тухай гүйцэтгэгч “Хос мөнгөн зам” ХХК-д удаа дараа албан бичгээр мэдэгдэн шаардлага хүргүүлсэн боловч өнөөг хүртэл ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна.

Ийнхүү шаардлагатай засварын ажил хийгдээгүйгээс болж уг авто замаар зорчиж буй иргэд амь нас, эд хөрөнгөөрөө хохирох ноцтой эрсдэлд байнга өртсөөр байна.

Авто замын сүлжээний бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор 2024 онд 180.14 сая төгрөгөөр нүхэн эвдрэлийг цементээр бэхжүүлсэн шороон материалаар дүүргэж түр зуурын арга хэмжээ авсан боловч эвдрэл улам ихсэж 2025 онд дахин 299.86 сая төгрөгөөр дээрх төрлийн түр зуурын засварын ажил хийх шаардлагатай болж байна.

Гарсан эвдрэлийн шалтгааныг мэргэжлийн байгууллагаас судлан шинжлэхэд замын далангийн сууринд хэрэглэсэн материал нь стандартын шаардлага хангахгүй болох нь тогтоогдож байгаа тул зураг төсөл хийж их засвар хийх зайлшгүй шаардлагатай болсон бөгөөд урьдчилан тооцож үзэхэд 26.0 тэрбум төгрөг шаардлагатай байна.

Иймд 2024, 2025 онд хийсэн түр засварын зардал болох нийт 480.0 сая төгрөг, их засварын зардал болох 26.0 тэрбум төгрөгийг концессын гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэгч “Хос мөнгөн зам” ХХК-аас шүүхийн журмаар гаргуулах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэхийг хүсье.

Захиалагч байгууллагын зүгээс уг замын эвдрэлийг гүйцэтгэгчээр засварлуулах талаар танай яаманд удаа дараа албан бичгээр мэдэгдэж ирсэн боловч өнөөг хүртэл зохих арга хэмжээ авагдаагүй байна.

Хэрэв уг асуудлыг цаашид шуурхай шийдвэрлэхгүй, шаардлагатай зардлыг гүйцэтгэгчээс гаргуулах арга хэмжээ авахгүй тохиолдолд гарах осол, хохирлын хариуцлагыг захиалагч байгууллага Эдийн засаг, хөгжлийн яам бүрэн хариуцах нөхцөл үүсээд байгаа болно. Холбогдох албан бичгүүд, шинжилгээний дүгнэлтүүдийг хавсаргав.

Хавсралт 26 хуудастай



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
ЯАМАНД

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251

Утас: (976-51) 2671 68, Факс: (976-11) 31 23 15,

Цахим шуудан: info@mrd.gov.mn,

Цахим хуудас: www.mrd.gov.mn

4228-10-02

№

13/4644

танай _____-ны № _____-т

Шалгалтын дагуу авах арга хэмжээний
тухай

Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 04/73 дугаартай удирдамжийн дагуу Увс, Завхан аймгийн нутаг дэвсгэр дэх Сонгино сумаас Хяргас нуурын зуун хаяа хүртэлх 135.7 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдал, баталгаат хугацаанд хийгдсэн засвар арчлалтын ажлын гүйцэтгэлд 2023 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр төлөвлөгөөт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Тус авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэлүүдийн засварын ажлыг цаг хугацаанд нь технологийн шаардлагын түвшинд гүйцэтгээгүйгээс авто замын асфальтбетон хучилтад торон хагарал, суурийн эвдрэл гарч байгаа тул гүйцэтгэгч байгууллагаас эвдрэлийн шалтгааныг тогтоолгож, тохирсон засварыг хийлгэхгүй бол цаашид эвдрэлийн хэмжээ нэмэгдэж, хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхээс гадна авто замын хэвийн ашиглалтад сөргөөр нөлөөлж, насжилтыг бууруулахад хүргэхээр байна.

Хяналт шалгалтын ажлын хэсэг нь илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар гүйцэтгэгч "Хос мөнгөн зам" ХХК-д хүлээлгэн өгсөн улсын ахлах байцаагчдын 04-00-02/007/184 дугаартай албан шаардлага, үүссэн нөхцөл байдал, цаашид анхаарах, авч хэрэгжүүлэх асуудлын талаар боловсруулсан 04-00-02/007/65 дугаартай дүгнэлтийг хавсралтаар хүргүүлж байна.

Улсын байцаагчдын гаргасан албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж, дүгнэлтийн дагуу холбогдох арга хэмжээг авч, цаашид хэрэгжүүлсэн талаарх мэдээллийг ирүүлж, хамтран ажиллана уу.

Хавсралт: 7 хуудастай.

Хувийг: Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар,


"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ,

"Ар Си Эс Си" ХХК,

"Завхан АЗЗА" ТӨХК-д

САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ТҮРГЭЙГ ТҮР БӨЛӨН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БАТ-ӨЛЗИЙ



030007975

Боловсруулагч:

Хянасан:

Хувь:

Огноо: 2023.09.29



"ХОС МӨНГӨН ЗАМ" ХХК-д

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА**

Засгийн газрын ХИЙЭМЭР "Хөгжлийн өсгөн чөлөө"

Сүхбаатар дүүрэг Улаанбаатар хот 14251

Утас: (976-311) 26 7 118, факс: (976-11) 31 23 15

Цахам дуудал: info@hmg.gov.mn

Цахуу хууд: hmg.gov.mn

0023.09.02 № 04-00-00/007/184

Илэрсэн дутагдлыг арилгуулах тухай

Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 04/73 дугаартай төлөвлөгөөт шалгалт хийх удирдамжийн дагуу Увс, Завхан аймгийн нутаг дэвсгэр дэх улсын чанартай А18 дугаартай Улаангом-Сонгино-Номрег чиглэлийн замын Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа хүртэлх 135.7 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдал, хийгдсэн засвар арчлалтын ажлын гүйцэтгэлд Авто замын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, норм дүрэм, стандартын хэрэгжилтийг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан нийтлэг эрх, үүргийн хүрээнд хянан шалгалаа.

Хяналт шалгалтыг Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагч Б.Бат-Өлзий ахлаж, Авто замын хяналтын улсын ахлах байцаагч Ш.Гэрэлт-Од, Ц.Дөлбадрах, Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга Ц.Эрдэнэ-Очир, мэргэжилтэн Б.Дархандаръяа нарын бүрэлдэхүүнтэйгээр "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын Бүс нутаг хариуцсан хяналтын инженер М.Дашбалжир, "Завхан АЗЗА" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Баттулга, ерөнхий инженер Д.Өнөрбаян болон бусад инженер техникийн ажилчдыг байлцуулан 2023 оны 09 дүгээр сарын 09-ний өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

Авто замын тухай мэдээлэл

Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар "Хос мөнгөн зам" ХХК-тай 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдөр "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.7 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн Барих-Шилжүүлэх (ВТ) концессын гэрээг байгуулсан байна. Тус авто замын төслийн барилгын ажлын байнгын хяналтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний ҮХГ/43 дугаартай гэрээг Үндэсний хөгжлийн газар 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр "Ар Си Эс Си" ХХК-тай байгуулсан байна.

Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.7 км хатуу хучилттай авто замын АНЗ/С-Н/02-2013 шифртэй зураг төслийг "Аварга зам" ХХК боловсруулж, улсын экспертизээр хянуулан Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвөөс 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдөр 1153/2013 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан байна.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас зохион байгуулсан ажлын хэсгээс концессын барих-шилжүүлэх (ВТ) гэрээгээр хэрэгжсэн "Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.7 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн барилгын ажлыг дуусгаж, тус замын хэсэгчилэн 83.3 км авто замын барилгын ажлыг 2019 оны 01 дугаар сарын 30-ны өдрийн 07/15/18 дугаартай, үлдэгдэл хэсэг болох 52.2 км авто замын барилгын ажлыг 2019 оны 12

819104

дугаар сарын 27-ны өдрийн 10/18/19 дугаартай дүгнэлтээр баталгаажуулан хүлээлгэн өгч тус тус байнгын ашиглалтад оруулсан байна.

Төлөвлөгөөт хяналт шалгалтыг дараах асуудлын хүрээнд хийж гүйцэтгэв. Үүнд:

1.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/39 дугаартай тушаалаар баталсан 04.2.7 кодтой "Авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдлыг шалгах хяналтын хуудас"-аар Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.7 км хатуу хучилттай авто замын ашиглалтын эрсдэлийг үнэлэхэд 40 хувь буюу "дунд" эрсдэлтэй үнэлэгдсэн.

2.Тус авто зам, замын байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажлын материал, байнгын ашиглалтад оруулсан ажлын хэсгийн дүгнэлт, хурлын тэмдэглэл, өгсөн үүрэг даалгаврын биелэлт, гүйцэтгэсэн ажлын баримт, тус замын засварын асуудалтай холбогдолтой бичгүүдийг тус тус судалж, газар дээр нь үзлэг шалгалтыг хийсэн.

Хяналт шалгалтаар дараах дутагдлууд илэрлээ. Үүнд:

1.Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.7 км хатуу хучилттай авто замын Хяргас нуур талаас 556 км-573 км хооронд хучилтад гарсан эвдрэлийн зарим хэсгийг нөхсөн боловч эвдрэлийн хэмжээ нэмэгдэж, дахин засварлах шаардлагатай байгаа;

2.Тус замын ан цав гагнах ажил хийгдээгүй, босоо тэмдэг болон километрийн тэмдгийн наалт хууларсан, зарим тэмдэг байхгүй, анхааруулах шонг хугарсан, нөхөн сэргээгүй байгаа;

3.Авто замын суурь, хучилтад гарсан эвдрэлийг засварлах нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж, чанарын хяналтын төлөвлөгөө, ажлын аргачлалын хамт зөвлөх байгууллагаар баталгаажуулаагүй байгаа нь Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын гүйцэтгэгч нь батлагдсан зураг төсөл, норм, норматив, техникийн баримт бичиг, техник, технологи, эрүүл ахуй, байгаль орчны болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг биелүүдэх үүрэгтэй заалт, Авто зам замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага 33БНБДЗН-008-2016-ийн холбогдох заалтууд тус тус зөрчигдөж байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8 дахь заалтыг үндэслэн холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор дээрх дутагдлуудыг арилгуулахаар ШААРДАХ нь:

1.Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.7 км хатуу хучилттай авто замд үүссэн эвдрэлийг холбогдох норм дүрмийн дагуу далан, суурь, хучилтыг засварлах нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж, чанарын хяналтын төлөвлөгөө, төслийн техникийн шаардлагад заасан алдаатай ажлыг засварлах заалтад нийцсэн аргачлалыг боловсруулж, зөвлөх байгууллагаар баталгаажуулах;

2.Тус чиглэлийн авто замын дагуу тэмдэг, анхааруулах шонг нөхөн сэргээж, зургаар баталгаажуулан ирүүлэх;

3.Гүйцэтгэгч байгууллагын зүгээс шаардлагатай хүн хүч, машин механизм, фонд төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулж, тус чиглэлийн авто замд хийгдэх дээрх ажлуудыг батлагдсан төлөвлөгөөний дагуу норм дүрэмд заасан цаг агаарын нөхцөлд гүйцэтгэж, зөвлөх байгууллагаар баталгаажуулан ирүүлэх ажлыг зохион байгуулан хэрэгжилтийг ирүүлэх зэрэг болно.

Албан шаардлагын хэрэгжилтийг хангаж, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь "Байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтан нь


хяналт шалгалтын өжилд дэмжлэг туслалцаа үзүүлж, хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хууль зөрчсөн үйл ажиллагааг зогсоох, холбогдох арга хэмжээ авах талаар таавсан шаардлагыг биелүүлж, дүнг тогтоосон хугацаанд нь албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй гэж зааснаар хэрэгжилтийн тайланг холбогдох баримт бичгийн хамт албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газар, Завхан аймгийн Засаг даргын Тамгын газарт 2023 оны 11 дүгээр сарын 03-ны дотор тус тус ирүүлэхийг мэдэгдье.

Албан шаардлагыг биелүүлээгүй, хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд ирүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 15.2 дахь зүйлийн холбогдох заалтаар хариуцлага тооцохыг анхааруулж байна.

Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14.1 дэх заалтын дагуу гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргах эрхтэйг мэдэгдье.

Хувийг: Эдийн засаг, хөгжлийн яам, Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар, "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ, "Ар Си Эс Си" ХХК-д.

АВТО ЗАМЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Ш.ГЭРЭЛТ-ОД

АВТО ЗАМЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Ц.ДӨЛБАДРАХ

ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН АВСАН:

"ХӨС-МӨНГӨН ЗАМ" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ

[Signature]
албан тушаал

[Signature]
гарын үсэг

[Signature]
овог, нэр



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМАНД

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
ДУГНАЛТ**

Засгийн газрын XIII байр, Чийглэсний өргөн чөлөө 11
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хэр. 14241
Утас: (078-51) 28 71 38 Факс: (078-11) 31 23 15
Цахим шүүдэл: info@mtg.gov.mn
Цахим хуудал: 1000 7 7 7 7

2023.09.20 № 04-00-02/007/65

**Авто замын ашиглалт, засварын ажлын
тухай**

Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 04/73 дугаартай төлөвлөгөөт шалгалт хийх удирдамжийн дагуу Увс, Завхан аймгийн нутаг дэвсгэр дэх улсын чанартай А18 дугаартай Улаангом-Сонгино-Нөмрөг чиглэлийн замын Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа хүртэлх 135.7 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдал, хийгдсэн засвар ажиллалтын ажлын гүйцэтгэл, Авто замын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, норм дүрэм, стандартын хэрэгжилтийг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд зөвхөн нийтлэг эрх, үүргийн хүрээнд хянан шалгалаа.

Хяналт шалгалтыг Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагч Б.Бат-Өлзий ахлаж, Авто замын хяналтын улсын ахлах байцаагч Ш.Гөрэлт-Од, Ц.Долбадрах, Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга Ц.Эрдэнэ-Очир, мэргэжилтэн Б.Дархандарьяа нарын бүрэлдэхүүнтэйгээр "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын Бүс нутаг хариуцсан хяналтын инженер М.Дашбалжир, "Завхан АЗЗА" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Баттулга, ерөнхий инженер Д.Өнөрбуян болон бусад инженер техникийн ажилчдыг байлцуулан 2023 оны 09 дүгээр сарын 09-ний өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

Авто замын тухай мэдээлэл

Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар "Хос мөнгөн зам" ХХК-тай 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдөр "Сонгино-сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.7 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн Барих-Шилжүүлэх (BT) концессын гэрээг байгуулсан байна. Тус авто замын төслийн барилгын ажлын байнгын хяналтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний УХЛ/43 дугаартай гэрээг Үндэсний хөгжлийн газар 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр "Ар Си Эс Си" ХХК-тай байгуулсан байна.

Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.7 км хатуу хучилттай авто замын А/VZ/S-H/02-2013 шифртэй зураг төслийг "Аварга зам" ХХК боловсруулж, улсын экспертизээр хянуулан Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвөөс 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдөр 1153/2013 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан байна.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас зохион байгуулсан ажлын хэсгээс концессын барих-шилжүүлэх (BT) гэрээгээр хэрэгжсэн "Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.7 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн барилгын ажлыг дуусгаж, тус замын хэсэгчилэн 83.3 км авто замын барилгын ажлыг 2019 оны 01 дугаар сарын 30-ны өдрийн

813558

07/15/18 дугаартай, үлдэгдэл хэрэг бодох 52.2 км авто замын барилгын ажлыг 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 10/18/19 дугаартай дүгнэлтээр баталгаажуулан хүлээлгэн өгч тус тус байнгын ашиглалтад оруулсан байна.

Төлөвлөгөөт хяналт шалгалтыг дараах асуудлын хүрээнд хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/39 дугаартай тушаалаар баталсан 04.2.7 кодтой "Авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдлыг шалгах хяналтын хуудас"-аар Сонгино сумас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.7 км хатуу хучилттай авто замын ашиглалтын эрсдэлийг үнэлэхэд 40 хувь буюу "дунд" эрсдэлтэй үнэлэгдсэн.

2. Тус авто зам, замын байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажлын материал, байнгын ашиглалтад оруулсан ажлын хэсгийн дүгнэлт, хурлын тэмдэглэл, өгсөн үүрэг даалгаврын биелэлт, гүйцэтгэсэн ажлын баримт, тус замын засварын асуудалтай холбогдолтой бичгүүдийг тус тус судалж, газар дээр нь үзлэг шалгалтыг хийсэн.

Авто замын ашиглалтын байдал, засварын ажлын талаар

Сонгино сумас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.7 км хатуу хучилттай авто замын Хяргас нуур талаас 556 км-573 км хоорондох авто замын суурь болон хучилттай технологийн эвдрэлийг 2022 оны 11 дүгээр сарын 13-наас 15-ны өдрүүдэд хүйтэн асфальтбетон хольцоор засварласан боловч 2023 оны 05 дугаар сарын авто замын үзлэгээр дахин эвдрэл гарч, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахгүй нөхцөл байдал үүссэн байна.

"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-аас 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 1/670 тоот албан бичгээр холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, зөвлөх, болон гүйцэтгэгч байгууллагуудад тус тус хүргүүлсэн байна. Түүнчлэн шинээр нүхэн эвдрэл үүсч байгаа тул яаралтай засварлуулах талаар дахин 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 1/1122 тоот албан бичгийг хүргүүлсэн байна.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 06/3004 тоот албан бичгээр зөвлөх "Ар Си Эс Си" ХХК-д концессын гэрээний 4.10-д "Зөвлөхчанаарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг концесс эзэмшигчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил доголдлыг арилгаж дуусах хүртэл хугацаагаар сунгана", 4.11-д "Зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр концесс эзэмшигч уг зөрчил, доголдлыг Зөвлөхийн мэдэлд заасан хугацаанд багтааж концесс эзэмшигч өөрийн зардлаар арилгана" гэж заасны дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, ажлын дүнгийн талаар мэдэгдэхээр шаардлага хүргүүлсэн байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргаас Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргад 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 03/3597 тоот албан бичгээр тус авто замд гарсан эвдрэлийг засварлаж, баталгаажуулаагүй тохиолдолд тухайн авто замыг хүлээн авах боломжгүй талаар мэдэгдсэн байна.

Гүйцэтгэгч "Хос мөнгөн зам" ХХК-д тус авто замын суурь болон хучилтад гарсан эвдрэлийг технологийн дагуу засварлах талаар Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 08/1503 тоот, зөвлөх "Ар Си Эс Си" ХХК-аас 2023 оны 07 дугаар сарын 26-ны 137/23 тоот, 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 176/23 тоот албан бичгээр тус тус шаардлага хүргүүлсэн байна.

Хяналт шалгалтаар дараах нөхцөл байдал тогтоогдлоо. Үүнд:

1. Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135,7 км хатуу хучилттай авто замын Хяргас нуур талаас 556 км-573 км хооронд хучилтад гарсан эвдрэлийн зарим хэсгийг нөхсөн боловч эвдрэлийн хэмжээ нэмэгдэж, дахин засварлах шаардлагатай байна.

2. Тус замын ан цав гагнах ажил хийгдээгүй, босоо тэмдэг болон километрийн тэмдгийн наалт хууларсан, зарим тэмдэг байхгүй, анхааруулах шон хугарсан, нөхөн сэргээгүй байна.

3. Авто замын суурь, хучилтад гарсан эвдрэлийг засварлах нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж, чанарын хяналтын төлөвлөгөө, ажлын аргачлалын хамт зөвлөх байгууллагаар баталгаажуулаагүй байна.

Газар дээр хийсэн шалгалт, үүссэн нөхцөл байдлыг үндэслэн **ДУГНОХ нь:**

1. Завхан аймгийн Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа хүртэлх 135,7 км хатуу хучилттай авто замын ашиглалт, засварын ажилд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн дээрх алдаа дутагдлууд нь тус авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэлүүдийн засварын ажил цаг хугацаанд технологийн шаардлагын түвшинд гүйцэтгээгүйгээс Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь /Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын гүйцэтгэгч нь батлагдсан зураг төсөл, норм, норматив, техникийн баримт бичиг, техник, технолог, эрүүл ахуй, байгаль орчны болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг биелүүлэх үүрэгтэй/ заалтын хэрэгжилт бүрэн хангагдахгүй хүргэж байна.

2. Гүйцэтгэгч байгууллага батлагдсан зураг төсөл, техникийн шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаагүйгээс Хяргас нуур талаас 556 км-573 км хооронд дээрх нөхцөл байдал үүссэн байгаа тул авто замын асфальтбетон хучилтад торон хагарал, суурийн эвдрэл гарч байгаа хэсэгт эвдрэлийн шалтгааныг тогтоож, тохирсон засварыг гүйцэтгэхгүй бол цаашид эвдрэлийн хэмжээ нэмэгдэж, хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхээс гадна авто замын хэвийн ашиглалтад сөргөөр нөлөөлж, насжилтыг бууруулахад хүргэхээр байна.

3. Гүйцэтгэгч байгууллагын зүгээс батлагдсан төлөвлөгөөний дагуу шаардлагатай хүн хүч, машин механизм, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулж, норм дүрэмд заасан цаг агаарын нөхцөлд төслийн техникийн шаардлагад заасан алдаатай ажлыг засварлах технологийн аргачлалыг мөрдөж, чанарын хяналтын төлөвлөгөөнд тусгагдсан лаборатори болон талбайн туршилт шинжилгээг хийж, зөвлөх байгууллагаар баталгаажуулан зураг төсөл, техникийн шаардлагад нийцүүлэх арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

4. Цаашид төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын Засгийн газартай байгуулсан концессын гэрээний үндсэн хэрэгжиж буй авто замын төсөл арга хэмжээний барилга угсралтын ажлыг зөвлөх байгууллагын техник технологийн хяналтын доор гүйцэтгэж, байнгын ашиглалтад оруулах, чанарын баталгаат хугацаанд төрийн захиргааны болон зөвлөх, хариуцагч байгууллагуудаас зураг төсөл, техникийн шаардлагыг хангасан эсэхэд үзлэг шалгалтыг хийлгэж, тухайн авто замыг холбогдох журмын дагуу хүлээлгэн өгч, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад онцгой анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Түүнчлэн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардлагатай мэргэжил арга зүйн зөвлөгөөг авах, авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажлын явц, чанарын баталгаат хугацаанд хийх хяналт шалгалтын ажлын уялдаа, төрийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

5. Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж байгаа байгууллагын хувьд "Хос мөнгөн зам" ХХК-тай байгуулсан "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.7 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн Барих-Шилжүүлэх (ВТ) концессын гэрээг дүгнэж гэрээний 4.10, 4.11 болон бусад заалтын хэрэгжилтийг хууль тогтоомж, батлагдсан зураг төсөл, стандарт, норм норматив, дүрэм журам, техникийн нөхцөл шаардлагыг хангуулан авто замын хэвийн ашиглалтын байдлыг бүрдүүлж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдалд нийцүүлэх нь зүйтэй байна.

Хувийг Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар, "Зам, тээврийн хэрэглийн төв" ТӨҮГ, "Хос мөнгөн зам" ХХК, "Ар-Си-Эс-Си" ХХК, "Завхан-АЗЗА" ТӨХК-д.

АВТО ЗАМЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Ш.ГЭРЭЛТ-ОД

АВТО ЗАМЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Ц.ДӨЛБАДРАХ



ЗАВХАН АЗЗА ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ М.БОЛД ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15170 Улаанбаатар хот, Чингэлтай дүүрс,
Барилгачдын талбай 13, Засгийн газрын XII байр,
Утас: 26-47-88, Факс: (976-51) 26-80-88

E-mail: info@inspection.gov.mn, http://www.inspection.gov.mn

Юм. 12.09 № 087/2908
танай _____ -ны № _____

**Хяналт шалгалтын дүн мэдээг
хүргүүлэх тухай**

Танай байгууллагаас ирүүлсэн авто замын ашиглалтын байдалд үүссэн нөхцөл байдлын тухай дурдсан 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 24 тоот албан бичигтэй танилцлаа.

Мэргэжлийн хяналтын байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 01/139 тоот удирдамжийн дагуу Увс, Завхан-аймгийн нутаг дэвсгэрт хийгдсэн шалгалтын хүрээнд улсын чанартай А18 дугаартай Нөмрөг-Сонгино-Наранбулаг чиглэлийн авто замын ашиглалт, засвар арчлалтын ажилд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хийж гүйцэтгэсэн.


Хяналт шалгалтад хамрагдсан тус авто замын ан цав гагнах ажил бүрэн хийгдээгүй, босоо тэмдэг болон километрийн тэмдгийн наалт хууларсан, зарим тэмдэг байхгүй, анхааруулах шонг хугарсан, нөхөн сэргээгүй, замын хучилтад эвдрэл гарч, зарим хэсгийг нөхсөн боловч нийт 1101.79 м² хучлагыг нэмэлтээр засварлах шаардлагатай зэрэг зөрчил дутагдлууд илэрсэн.

Иймд Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135,7 км хатуу хучилттай авто замд үүссэн эвдрэлийг цаг агаарын тохиромжтой хугацаанд холбогдох норм дүрмийн дагуу засварлах аргачлалыг боловсруулан баталгаажуулж, түүний дагуу засварын ажлыг хийж гүйцэтгэх, тэмдэг, анхааруулах шонг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэхээр улсын ахлах байцаагчийн гаргасан 01-07-035/275 тоот албан шаардлагыг концесс эзэмшигч "Хос мөнгөн зам" ХХК, зөвлөх "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-т тус тус хүргүүлсэн.

Хяналт шалгалтаар үүссэн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх асуудлын талаар улсын ахлах байцаагчийн гаргасан 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01-07-035/275 тоот албан шаардлагыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.

ДЭД БҮТЦИЙН ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА _____ Д. ЖАРГАЛ



Scanned with CamScanner

09 03528



0000000307

"ХОС МӨНГӨН ЗАМ" ХХК-Д

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар,
15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 13, Засгийн газрын XII байр
Утас: 26-47-86, Факс: (976-51) 26-60-88
E-mail: info@inspection.gov.mn
http://www.inspection.gov.mn

2021.11.15 № 01-07-035/2021

Илэрсэн дутагдлыг арилгуулах тухай

Монгол Улсын Шадар сайдын тушаалаар батлагдсан Мэргэжлийн хяналтын байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, МХЕГ-ын даргын баталсан 01/139 тоот удирдамжийн дагуу Увс, Завхан аймгийн нутаг дэвсгэр дэх улсын чанартай Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135,7 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдал, засвар арчлалтын ажлын явцад Төрийн хяналт шалгалтын тухай, Авто замын тухай, Барилгын тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, норм дүрэм, стандартын хэрэгжилтэд хамтарсан хяналт шалгалтыг хийлээ.

Хяналт шалгалтын үйл ажиллагааг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Зам, тээвэр, холбоо мэдээллийн хяналтын хэлтсийн дарга Ш.Гэрэлт-Од ахалж, Авто замын хяналтын улсын байцаагч Ц.Долбадрах нар зөвлөх "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын Замын засвар арчлалтын хяналтын хэлтсийн бүс нутаг хариуцсан хяналтын инженер У.Эрдэнэбилэг, тус чиглэлийн улсын чанартай замын хариуцагч "Завхан АЗЗА" ТӨХК-ийн ерөнхий инженер Р.Батсүх нарыг байлцуулан 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газрын төлөөлж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний хөгжлийн газар "Хос мөнгөн зам" ХХК-тай 2016 онд байгуулсан "Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135,7 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн барих-шилжүүлэх (BT) концессын гэрээний дагуу тус чиглэлийн авто зам, замын байгууламжийг барьж байгуулсан байна.

Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135,7 км хатуу хучилттай авто замын AVZ/S-H/02-2013 шифртэй зураг төслийг "Аварга зам" ХХК боловсруулж, Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвөөс зураг төсөлд магадлал хийж, 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдөр 1153/2013 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан байна.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас зохион байгуулсан ажлын хэсгээс концессын барих-шилжүүлэх (BT) гэрээгээр хэрэгжсэн "Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135,7 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн барилгын ажлыг дуусгаж, тус замын хэсэгчилэн 83,3 км авто замын барилгын ажлыг 2019 оны 01 дугаар сарын 30-ны өдрийн 07/15/18 дугаартай, үлдэгдэл хэсэг болох 52,2 км авто замын барилгын

ажлыг 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 10/18/19 дугаартай дүгнэлтээр баталгаажуулан хүлээлгэн өгч, тус тус байнгын ашиглалтад оруулсан байна.

Хяналт шалгалтаар дараах дутагдлууд илэрлээ. Үүнд:

1. Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135,7 км хатуу хучилттай авто замын Км556+075, Км556+700, Км557+100, Км 557+400, Км560+300, Км 560+350, Км 560+400, Км560+750, Км560+850, Км 563+150, Км569+900, Км572+100, Км572+300, Км572+425, Км572+500, Км572+550, Км572+570, Км572+700, Км572+800, Км572+950, Км573+020-ийн хучилтад эвдрэл гарч, зарим хэсгийг нөхсөн боловч нийт 1101.79 м2 хучлагын засварлах шаардлагатай байгаа нь "Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага" 33БНБД 31-008-2016-ийн холбогдох заалтууд;

2. Тус замын ан цав гагнах ажил хийгдээгүй, босоо тэмдэг болон километрийн тэмдгийн наалт хууларсан, зарим тэмдэг байхгүй, анхааруулах шон хугарсан, нөхөн сэргээгүй байгаа нь "Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын техникийн шаардлага"-ын холбогдох заалтууд, "Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын техникийн шаардлага"-ын холбогдох заалтууд, Авто замын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.1 дэх "авто замын ашиглалтын байнгын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангах" заалт тус тус зөрчигдөж байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8 дахь заалтыг үндэслэн холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор дээрх зөрчлүүдийг арилгуулахаар **ШААРДАХ** нь:

1. Сонгино сумаас Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135,7 км хатуу хучилттай авто замд үүссэн эвдрэлийг цаг агаарын тохиромжтой хугацаанд холбогдох норм дүрмийн дагуу засварлах аргачлалыг боловсруулан баталгаажуулж, түүний дагуу засварын ажлыг хийж гүйцэтгэх;

2. Тус чиглэлийн авто замын дагуу тэмдэг, анхааруулах шонг нөхөн сэргээж, зургаар баталгаажуулан ирүүлэх;

3. Тус чиглэлийн авто замд хийгдэх дээрх ажлуудыг тохиромжтой цаг агаарын нөхцөлд хийх нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж, ажлын аргачлалын хамт зөвлөх байгууллагаар баталгаажуулан ирүүлэх ажлыг зохион байгуулан хэрэгжилтийг ирүүлэх зэрэг болно.

Албан шаардлагын хэрэгжилтийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн дотор биелүүлэх арга хэмжээ авч, зөвлөх байгууллагаар баталгаажуулж, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 /Байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтан нь хяналт шалгалтын ажилд дэмжлэг туслалцаа үзүүлж, хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хууль зөрчсөн үйл ажиллагааг зогсоох, холбогдох арга хэмжээ авах талаар тавьсан шаардлагыг биелүүлж, дүнг тогтоосон хугацаанд нь албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй/ дахь заалтын дагуу албан ёсоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Дэд бүтцийн хяналтын газарт ирүүлэхийг мэдэгдье.



0000000393

Албан шаардлагыг тогтоосон хугацаанд нь биелүүлээгүй, биелэлтийг Мэргэжлийн хяналтын байгууллагад гаргаж ирүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 15.2 дахь зүйлийн холбогдох заалтын дагуу хариуцлага тооцохыг анхааруулж байна.

Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14.1 заасан заалтын дагуу гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргах эрхтэйг мэдэгдье.

АВТО ЗАМЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



ШГЭРЭЛТ-ОД


АВТО ЗАМЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ




Ц.ДӨЛБАДРАХ

ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН АВСАН:


албан тушаал


гарын үсэг


овог, нэр